A07832



# МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2018 ОНЫ ЭХНИЙ 10 САРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1. *Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл*

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2018 оны эхний 10 сарын байдлаар 7,519.5 тэрбум төгрөг, нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 7,177.6 тэрбум төгрөг болж, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 341.9 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна. Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл өмнөх оны мөн үеэс 1,011.1 тэрбум төгрөгөөр, тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 2,961.6 тэрбум төгрөгөөр тус тус буурч сайжирсан байна.

**График 1**. Нэгдсэн төсвийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/




2018 оны эхний 10 сарын байдлаар нийт тэнцвэржүүлсэн улсын төсвийн орлого 1,246.5 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 19.5 тэрбум, нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого 94.1 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн тэнцвэржүүлсэн орлого 28.5 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс давж биелсэн байна.

2018 оны 10 дугаар сарын гүйцэтгэлээр нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого нь өнгөрсөн оны мөн үеэс 28.9 хувь буюу 1,684.1 тэрбум төгрөгөөр, төсвийн нийт зарлага нь 10.3 хувь буюу 673.0 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн бөгөөд төсвийн орлогын өсөлт зарлагын өсөлтөөс 18.5 пунктээр өндөр байгаа нь нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1,011.1 тэрбум төгрөгөөр буурахад нөлөөлжээ.

Нэгдсэн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр

*Хүснэгт 1.* */тэрбум төгрөг/*

| | ӨО-ны мөн үеийн | 2018 оны эхний 10 дугаар сар | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөв. | Гүйцэт. | Хувь | Зөрүү |
| Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 177.8 | 1,034.8 | 1,170.9 | 113.2 | -136.1 |
| **Засгийн газрын бонд** | **210.4** | **-680.1** | **-2,337.8** | **343.7** | **1,657.7** |
| Засгийн газрын зээл | 183.1 | 1,997.2 | 715.8 | 35.8 | 1,281.4 |
| **Ирээдүйн өв сангийн шилжүүлэг** | **83.0** | **100.0** | **100.0** | **100.0** | **0.0** |
| Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл | 0.0 | 104.1 | 0.0 | 0.0 | 104.1 |
| **Өмч хувьчлал** | **14.9** | **63.7** | **9.2** | **14.5** | **54.5** |
| **НИЙТ ДҮН** | **669.2** | **2,619.7** | **-341.9** | **-13.1** | **2,961.6** |

*Эх сурвалж: Сангийн яам*

2018 оны эхний 10 сарын байдлаар гадаад төслийн зээлийн үндсэн төлбөрт 228.2 тэрбум, Засгийн газрын урт хугацаат дотоод бондын үндсэн төлбөрт 1,670.8 тэрбум болон гадаад бондын үндсэн төлбөрт 667.0 тэрбум төгрөгийг тус тус төлж, шинээр авсан гадаад төслийн зээлийн хэмжээ 574.9 тэрбум төгрөгт хүрчээ. Шинээр Засгийн газрын урт болон богино хугацаат дотоод, гадаад бонд гаргаагүй байна.

## 2. *Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого*

***Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 7,519.5 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 28.9 хувь буюу 1,684.1 тэрбум төгрөгөөр өсч, тайлант хугацааны орлогын төлөвлөгөө 23.5 хувь буюу 1,431.8 тэрбум төгрөгөөр давж биелсэн үзүүлэлттэй байна.***

Нийт тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн шатлал бүрээр нь авч үзвэл улсын төсөв 28.9 хувь буюу 1,246.5 тэрбум төгрөгөөр, орон нутгийн төсөв 0.9 хувь буюу 19.5 тэрбум төгрөгөөр, нийгмийн даатгалын сангийн төсөв 6.0 хувь буюу 94.1 тэрбум төгрөгөөр, эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв 9.2 хувь буюу 28.5 тэрбум төгрөгөөр тус тус давж биелжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад улсын төсвийн нийт орлого 33.5 хувь буюу 1,393.7 тэрбум, орон нутгийн төсвийн орлого 15.9 хувь буюу 301.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, харин нийгмийн даатгалын сангийн орлого 1.9 хувь буюу 32.0 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Нэгдсэн төсвийн орлогын 2018 оны 10 дугаар сарын гүйцэтгэл, төсвийн шатлалаар

***Хүснэгт 2.*** */тэрбум төгрөг/*

| Ангилал | Улсын төсөв | | Орон нутгийн төсөв | | НДС | | ЭМДС | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Төлөв. | Гүйцэт. | Төлөв. | Гүйцэт. | Төлөв. | Гүйцэт. | Төлөв. | Гүйцэт. |
| НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | **4,835.6** | **6,306.3** | **2,180.3** | **2,199.9** | **1,572.4** | **1,666.4** | **308.7** | **337.1** |
| ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН | 104.1 | 189.2 | - | - | - | - | - | - |
| ИРЭЭДҮЙН ӨВ САН | 420.3 | 559.4 | - | - | - | - | - | - |
| НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | **4,311.2** | **5,557.7** | **2,180.3** | **2,199.9** | **1,572.4** | **1,666.4** | **308.7** | **337.1** |
| ***Татварын орлого*** | *3,151.7* | *4,528.3* | *894.9* | *905.5* | *1,057.7* | *1,151.7* | *308.7* | *337.1* |
| Орлогын албан татвар | 569.6 | 1,125.9 | 611.6 | 628.9 | - | - | - | - |
| Нийгмийн даатгалын орлого | - | - | - | - | 1,057.7 | 1,151.7 | 308.7 | 337.1 |
| Хөрөнгийн албан татвар | - | - | 107.2 | 114.0 | - | - | - | - |
| Нэмэгдсэн өртгийн албан татвар | 1,227.7 | 1,755.9 | - | - | - | - | - | - |
| Онцгой албан татвар | 560.4 | 621.0 | - | - | - | - | - | - |
| Тусгай зориулалтын орлого | 10.4 | 10.6 | - | - | - | - | - | - |
| Гадаад үйл ажиллагааны орлого | 451.1 | 554.3 | - | - | - | - | - | - |
| Бусад татвар, төлбөр, хураамж | 332.5 | 460.6 | 176.2 | 162.6 | - | - | - | - |
| ***Татварын бус орлого*** | *1,159.5* | *1,029.4* | *1,285.4* | *1,294.4* | *514.7* | *514.7* | *0.0* | *0.0* |
| Нийтлэг татварын бус орлого | 637.8 | 623.1 | 146.5 | 154.3 | - | - | - | - |
| Хөрөнгийн орлого | 0.0 | 0.0 | 0.7 | 0.4 | - | - | - | - |
| Тусламжийн орлого | 278.4 | 191.0 | 1.7 | 3.2 | 514.7 | 514.7 | 0.0 | 0.0 |
| Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 243.3 | 215.3 | 1,136.5 | 1,136.5 | - | - | - | - |

*Эх сурвалж: Сангийн яам*

**График 2.** Нэгдсэн төсвийн орлогын бүтэц /хувиар/




Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 89.3 хувийг татварын орлого, 10.7 хувийг татварын бус орлого эзэлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татварын орлого 32.2 хувь буюу 1,637.7 тэрбум, татварын бус орлого 6.2 хувь буюу 46.4 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

***Татварын орлого 6,718.5 тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөө 29.2 хувь буюу 1,517.0 тэрбум төгрөгөөр давж биелжээ.***

Татварын орлогын 26.1 хувийг орлогын албан татвар, 19.1 хувийг нийгмийн даатгалын орлого, 1.7 хувийг хөрөнгийн албан татвар, 26.1 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 9.2 хувийг онцгой албан татвар, 0.2 хувийг тусгай зориулалтын орлого, 8.3 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 9.3 хувийг бусад татвар, төлбөр, хураамжийн орлого бүрдүүлж байна.

**График 3.** Татварын орлого /тэрбум төгрөг/




| | Орлогын албан татвар | Нийгмийн даатгалын орлого | Хөрөнгийн албан татвар | Нэмэгдсэн өртгийн албан татвар | Онцгой албан татвар | Тусгай зориу-лалтын орлого | Гадаад үйл ажил-лагааны орлого | Бусад татвар, төлбөр, хураамж |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| ■ Төлөвлөгөө | 1,181.2 | 1,154.9 | 107.2 | 1,227.7 | 560.4 | 10.4 | 451.1 | 508.7 |
| ≡ Гүйцэтгэл | 1,754.9 | 1,284.7 | 114.0 | 1,755.9 | 621.0 | 10.6 | 554.3 | 623.2 |

Тайлант хугацаанд бүх төрлийн татварын орлогууд давж биелсэн байна. Үүнд: нэгдсэн төсвийн орлогын албан татвар 48.6 хувь /573.7 тэрбум.төг/, нийгмийн даатгалын орлого 11.2 хувь /129.8 тэрбум.төг/, хөрөнгийн албан татвар 6.4 хувь /6.8 тэрбум.төг/, нэмэгдсэн өртгийн албан татвар 43.0 хувь /528.1 тэрбум.төг/, онцгой албан татвар 10.8 хувь буюу /60.6 тэрбум.төг/, тусгай зориулалтын орлого 2.1 хувь /0.2 тэрбум.төг/ гадаад үйл ажиллагааны орлого 22.9 хувь /103.2 тэрбум.төг/, бусад татвар, төлбөр хураамж 22.5 хувь /114.5 тэрбум.төг/-аар тус тус давж биелэв.

***Давж биелсэн нийт татварын орлогын өсөлтийн 37.8 хувийг орлогын албан татвар, 34.8 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 8.6 хувийг нийгмийн даатгалын орлого, 7.5 хувийг бусад татвар, төлбөр хураамжийн орлого, 6.8 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 4.0 хувийг онцгой албан татвар, 0.4 хувийг хөрөнгийн албан татвар эзэлжээ.***

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2018 оны 10 дугаар сарын байдлаар татварын орлого 1,637.7 тэрбум төгрөг буюу 32.2 хувиар өсөхөд тусгай зориулалтын орлого 0.1 тэрбум (0.6%) төгрөгөөр буурсан ч орлогын албан татвар 427.3 тэрбум (32.2%), нийгмийн даатгалын орлого 245.3 тэрбум (23.6%), хөрөнгийн албан татвар 17.0 тэрбум (17.5%), нэмэгдсэн өртгийн албан татвар 444.2 тэрбум (33.9%), онцгой албан татвар 210.9 тэрбум (51.4%), гадаад үйл ажиллагааны орлого 147.9 тэрбум (36.4%), бусад татвар, төлбөр, хураамж 145.0 тэрбум (30.3%) төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

***Татварын орлогын өсөлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 27.1 хувийг нэмэгдсэн өртгийн албан татвар, 26.1 хувийг орлогын албан татвар, 15.0 хувийг нийгмийн даатгалын орлого, 12.9 хувийг онцгой албан татвар, 9.0 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 8.9 хувийг бусад татвар, төлбөр, хураамж, 1.0 хувийг хөрөнгийн албан татвар эзэлж байна.***

***Татварын бус орлого 801.0 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 6.2 хувь буюу 46.4 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, төлөвлөснөөс 85.2 тэрбум төгрөг буюу 9.6 хувиар дутуу төвлөрсөн байна.***

Татварын бус орлого дутуу төвлөрөхөд төсөвт байгууллагын өөрийн орлого 66.2 тэрбум төгрөгөөр, тусламжийн орлого 77.9 тэрбум төгрөгөөр дутуу төвлөрсөн нь голлон нөлөөлжээ. Харин хувьцааны ногдол ашиг 13.6 тэрбум, хүүгийн орлого 27.8 тэрбум, торгуулийн орлого 19.1 тэрбум, бусад орлого 6.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс илүү төвлөрчээ.

**График 4.** Татварын бус орлогын бүтэц /хувиар/




Татварын бус орлогын 97.1 хувийг нийтлэг татварын бус орлого, 2.9 хувийг тусламжийн орлого эзэлж байна. Нийтлэг татварын бус орлогын 30.0 хувийг төсөвт байгууллагын өөрийн орлого, 22.7 хувийг газрын тосны орлого, 17.8 хувийг навигацийн орлого, 9.8 хувийг хувьцааны ногдол ашиг, 7.8 хувийг бусад орлого, 6.3 хувийг торгуулийн орлого, 5.4 хувийг хүүгийн орлого, 0.2 хувийг түрээсийн орлого тус тус эзэлж байна.

***Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн дагуу 22 төсвийн ерөнхийлөн захирагч улсын төсөвт орлого төвлөрүүлэх үүрэг хүлээсний 10 нь төлөвлөсөн орлогыг давуулан биелүүлсэн бол үлдсэн 12 нь 5.8-100.0 хувь дутуу төвлөрүүлсэн гүйцэтгэлтэй байна. Татварын ерөнхий газар 70.0 хувь, Гаалийн ерөнхий газар 24.9 хувиар тус тус давуулан биелүүлсэн байна.***

2018 оны 10 сард улсын төсвийн ерөнхийлөн захирагч,
түүний харьяа байгууллагын төвлөрүүлэх орлого

*Хүснэгт 3.* */сая төгрөг/*

| Төсвийн ерөнхийлөн захирагч | Өмнөх оны мөн үеийн | 2018 оны 10 дугаар сарын гүйцэтгэл | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| **Сангийн сайд** | 3,982,007.5 | 4,091,878.9 | 5,557,325.0 | 1,465,446.1 | 135.8 |
| Татварын ерөнхий газар | 2,317,238.2 | 1,830,261.6 | 3,110,800.3 | 1,280,538.7 | 170.0 |
| Үүнээс:Тогтворжуулалтын сан | - | 201,070.2 | 189,216.4 | -11,853.7 | 94.1 |
| Ирээдүйн өв сан | - | 372,479.3 | 559,372.2 | 186,892.9 | 150.2 |
| Гаалийн ерөнхий газар | 1,547,780.9 | 1,780,310.1 | 2,222,794.6 | 442,484.6 | 124.9 |
| Сангийн яам | 49,642.8 | 386,613.2 | 160,799.9 | -225,813.3 | 41.6 |
| Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт | 7,742.7 | 74,547.0 | 56,249.0 | -18,298.0 | 75.5 |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 8,176.1 | 17,171.3 | 1,576.7 | -15,594.5 | 9.2 |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 51,426.8 | 2,975.7 | 5,104.5 | 2,128.7 | 171.5 |
| **Монгол Улсын Их Хурлын дарга** | 9,277.8 | 2,684.9 | 1,728.6 | -956.4- | 64.4 |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 9,277.8 | 2,684.9 | 1,728.6 | -956.4 | 64.4 |
| **Монгол Улсын Ерөнхий аудитор** | 1,226.1 | 87.6 | 364.0 | 276.4 | 415.7 |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 1,226.1 | 87.6 | 364.0 | 276.4 | 415.7 |
| **Монгол Улсын Ерөнхий сайд** | 40,234.8 | 126,997.3 | 47,479.3 | -79,518.0 | 37.4 |
| Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан | 1,342.8 | 2,250.0 | 1,800.0 | -450.0 | 80.0 |
| Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | 24,388.3 | 121,842.5 | 42,444.4 | -79,398.1 | 34.8 |
| Үүнээс: Ирээдүйн өв сан | - | 47,842.5 | 0.0 | -47,842.5 | - |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 14,503.7 | 2,904.8 | 3,234.9 | 330.1 | 111.4 |
| **Монгол Улсын Шадар сайд** | 32,390.7 | 9,649.3 | 15,081.2 | 5,431.8 | 156.3 |
| Мэргэжлийн хяналтын ерөнхий газар | 3,064.0 | 2,180.4 | 2,843.9 | 663.5 | 130.4 |
| Стандарт, хэмжил зүйн газар | 2,173.6 | 2,222.1 | 3,234.4 | 1,012.3 | 145.6 |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 7,294.3 | 2,006.0 | 2,663.1 | 657.1 | 132.8 |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 19,858.8 | 3,240.9 | 6,339.8 | 3,098.9 | 195.6 |
| **Хууль зүй, дотоод хэргийн сайд** | 97,430.5 | 38,305.4 | 38,569.8 | 264.4 | 100.7 |
| Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар | 14,780.8 | 17,010.6 | 15,536.0 | -1,474.6 | 91.3 |
| Цагдаагийн ерөнхий газар | 1,182.4 | 2,906.3 | 1,578.1 | -1,328.2 | 54.3 |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | - | 625.5 | 0.0 | -625.5 | - |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого | 15,594.2 | 4,579.4 | 4,453.7 | -125.7 | 97.3 |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 65,873.1 | 13,183.7 | 17,002.1 | 3,818.3 | 129.0 |
| **Гадаад харилцааны сайд** | 20,878.5 | 19,814.4 | 23,438.1 | 3,623.8 | 118.3 |
| Дипломат төлөөлөгчийн газрууд | 17,611.9 | 18,522.7 | 21,287.2 | 2,764.6 | 114.9 |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 3,266.6 | 1,291.7 | 2,150.9 | 859.2 | 166.5 |
| **Зам, тээврийн хөгжлийн сайд** | 141,183.5 | 140,988.4 | 146,182.3 | 5,193.9 | 103.7 |
| Иргэний нисэхийн ерөнхий газар | 102,760.8 | 138,172.8 | 138,179.2 | 6.4 | 100.0 |
| Зам, тээврийн хөгжлийн яам | 142.5 | 168.6 | 168.5 | -0.1 | 99.9 |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 6,286.1 | 855.4 | 1,101.9 | 246.6 | 128.8 |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 31,994.1 | 1,791.6 | 6,732.7 | 4,941.1 | 375.8 |
| **Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд** | 223,055.9 | 253,570.8 | 220,130.4 | -33,440.4 | 86.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Ашигт малтмал, газрын тосны газар | 189,267.1 | 248,071.4 | 218,471.2 | -29,600.2 | 88.1 |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 33,788.8 | 5,499.4 | 1,659.2 | -3,840.2 | 30.2 |
| **Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд** | 238,171.1 | 60,173.9 | 28,642.0 | -31,531.9 | 47.6 |
| Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар | 420.0 | 443.7 | 410.0 | -33.7 | 92.4 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого | 1,907.9 | 525.9 | 392.2 | -133.8 | 74.6 |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 35,597.5 | 9,204.0 | 0.0 | -9,204.0 | - |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 200,245.7 | 50,000.3 | 27,839.8 | -22,160.5 | 55.7 |
| **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд** | 658,611.5 | 109,302.1 | 147,246.9 | 37,944.8 | 134.7 |
| Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлт | 243,984.7 | 43,167.7 | 101,946.4 | 58,778.7 | 236.2 |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 38,477.8 | 1,414.6 | 103.0 | -1,311.7 | 7.3 |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 376,149.0 | 64,719.8 | 45,197.6 | -19,522.2 | 69.8 |
| **Эрүүл мэндийн сайд** | 811,129.8 | 194,882.0 | 183,675.4 | -11,206.6 | 94.2 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгох санхүүжилтийн орлого | 711,620.1 | 168,419.5 | 161,379.7 | -7,039.8 | 95.8 |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 6,063.2 | 2,015.0 | 248.7 | -1,766.3 | 12.3 |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 93,446.5 | 24,447.4 | 22,046.9 | -2,400.5 | 90.2 |
| **Байгаль орчин, аялал жуулчлалын сайд** | 55,467.2 | 9,887.5 | 7,224.2 | -2,663.3 | 73.1 |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 53,065.6 | 9,616.8 | 6,385.5 | -3,231.3 | 66.4 |
| Харьяалагдах төсөвт байгууллагуудын өөрийн орлого | 2,401.6 | 270.7 | 838.7 | 568.0 | 309.8 |
| **Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга** | 3,346.6 | 383.9 | 1,053.4 | 669.5 | 274.4 |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 2,784.9 | 265.2 | 415.6 | 150.5 | 156.7 |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 561.7 | 118.8 | 637.8 | 519.0 | 537.1 |
| **Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд** | 40,605.5 | 60,984.9 | 8,224.6 | -52,760.3 | 13.5 |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 15,003.0 | 56,969.1 | 3,448.9 | -53,520.2 | 6.1 |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 25,602.5 | 4,015.9 | 4,775.7 | 759.8 | 118.9 |
| **Барилга, хот байгуулалтын сайд** | 763.3 | 1,807.5 | 1,215.0 | -592.5 | 67.2 |
| Газар зохион байгуулалт, геодези, зурагзүйн газар | 763.3 | 1,464.3 | 1,215.0 | -249.3 | 83.0 |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | - | 343.2 | 0.0 | -343.2 | - |
| **Батлан хамгаалахын сайд** | 221,641.5 | 45,172.3 | 35,179.1 | -9,993.2 | 77.9 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас улсын эмнэлэгт олгох санхүүжилтийн орлого | 18,964.1 | 5,516.9 | 4,823.4 | -693.5 | 87.4 |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 202,677.4 | 39,655.4 | 30,355.7 | -9,299.7 | 76.5 |
| **Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга** | 743.8 | 50.0 | 91.3 | 41.3 | 182.5 |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 743.8 | 50.0 | 91.3 | 41.3 | 182.5 |
| **Санхүүгийн зохицуулах хороо** | 3,426.7 | 659.9 | 661.4 | 1.5 | 100.2 |
| Харьяалагдах төсөвт байгууллагын өөрийн орлого | 3,426.7 | 659.9 | 661.4 | 1.5 | 100.2 |
| **Үндэсний статистикийн хорооны дарга** | 3,057.7 | 24.4 | 4.9 | -19.4 | 20.3 |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | 3,039.2 | 24.4 | 0.0 | -24.4 | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Улсын ерөнхий прокурор** | - | - | - | - | - |
| Гадаад тусламжийн орлогоос санхүүжих | - | - | - | - | - |
| **Эрчим хүчний сайд** | - | 4,016.0 | 1,924.8 | -2,091.3 | 47.9 |
| **Гадаад тусламжийн орлогоос санхүүжих** | **-** | **4,016.0** | **1,924.8** | **-2,091.3** | **47.9** |

*Эх сурвалж: Сангийн яам*

## *3. Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээл*

***Тайлант хугацаанд нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлд 8,707.4 тэрбум төгрөг зарцуулахаар төлөвлөсний 82.4 хувийг ашиглаж 1,529.8 тэрбум төгрөг дутуу зарцуулжээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн нийт зарлага 673.0 тэрбум төгрөг буюу 10.3 хувиар өсч 7,177.6 тэрбум төгрөг зарцуулагдсан байна.***

Нэгдсэн төсвийн зарлагын 2018 оны 10 дугаар сарын гүйцэтгэл /*төсвийн шатлалаар*/
***Хүснэгт 4.*** */тэрбум төгрөг/*

| | **Улсын төсөв** | | **Орон нутгийн төсөв** | | **НДС** | | **ЭМДС** | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | **Төлөв.** | **Гүйцэт.** | **Төлөв.** | **Гүйцэт.** | **Төлөв.** | **Гүйцэт.** | **Төлөв.** | **Гүйцэт.** |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 6,703.8 | 5,637.7 | 2,501.0 | 2,041.6 | 1,502.5 | 1,498.1 | 285.0 | 241.9 |
| НИЙТ ЗАРЛАГА | 6,410.5 | 5,364.4 | 2,468.1 | 2,025.2 | 1,502.5 | 1,498.1 | 285.0 | 241.9 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 5,040.1 | 4,615.0 | 1,933.5 | 1,728.9 | 1,502.5 | 1,498.1 | 285.0 | 241.9 |
| Бараа, ажил үйлчилгээний зардал | 1,800.4 | 1,516.7 | 1,260.2 | 1,140.8 | 15.8 | 14.7 | 3.6 | 2.4 |
| Зээлийн үйлчилгээний төлбөр | 971.1 | 897.4 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| Татаас | 596.3 | 574.8 | 87.4 | 79.1 | 0.0 | 0.0 | 39.6 | 27.6 |
| Урсгал шилжүүлэг | 1,672.3 | 1,626.1 | 585.9 | 509.0 | 1,486.7 | 1,483.4 | 241.8 | 211.8 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,370.4 | 749.4 | 534.6 | 296.3 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 293.3 | 273.2 | 32.9 | 16.5 | 0.0 | 0.0 | 0.0 | 0.0 |
| НИЙТ ТЭНЦЭЛ | -2,392.6 | -80.0 | -320.6 | 158.2 | 69.8 | 168.4 | 23.7 | 95.3 |

*Эх сурвалж: Сангийн яам*

Тайлант хугацаанд төлөвлөснөөс улсын төсвийн зарлага 1,066.2 тэрбум, орон нутгийн төсвийн зарлага 459.3 тэрбум, нийгмийн даатгалын сангийн зарлага 4.5 тэрбум, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 43.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулагджээ.

Өмнөх оны мөн үеэс улсын төсвийн нийт зарлага 520.5 тэрбум, орон нутгийн төсвийн зардал 267.9 тэрбум төгрөгөөр тус тус өсч, нийгмийн даатгалын сангийн зардал 41.1 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл өнгөрсөн оны мөн үеэс 10.3 хувь буюу 673.0 тэрбум төгрөгөөр өсөхөд урсгал зардал 8.2 хувь буюу 442.9 тэрбум төгрөгөөр, хөрөнгийн зардал 12.2 хувь буюу 113.3 тэрбум төгрөгөөр, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 67.6 хувь буюу 116.8 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад бараа, ажил үйлчилгээний зардал 5.5 хувь буюу 132.6 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 1.3 хувь буюу 11.7 тэрбум, урсгал

шилжүүлэг 17.3 хувь буюу 331.3 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдсэн бол татаас 16.4 хувь буюу 32.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

***Зээлийн үйлчилгээний төлбөр нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11.7 тэрбум төгрөгөөр өссөн боловч тайлант хугацааны төлөвлөсөн дүнгээс 73.6 тэрбум төгрөгөөр буюу 7.6 хувиар бага байгаа нь тайлант хугацаанд улсын төсөвт нөлөөлөх хүүгийн зардал буурах төлвийг харуулж байна.***

Нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн гүйцэтгэл
/зардлын эдийн засгийн ангиллаар/

*Хүснэгт 5.* */тэрбум төгрөг/*

| | ӨО-ны мөн үеийн | 2018 оны эхний 10 сарын гүйцэтгэл | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөв. | Гүйцэт. | Хувь | Зөрүү |
| **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 6,504.6 | 8,707.4 | 7,177.6 | 82.4 | 1,529.8 |
| НИЙТ ЗАРЛАГА | **6,331.7** | **8,381.2** | **6,887.9** | **82.2** | **1,493.3** |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 5,399.3 | 6,476.2 | 5,842.2 | 90.2 | 634.0 |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,394.1** | **2,925.0** | **2,526.6** | **86.4** | **398.4** |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,437.7 | 1,558.5 | 1,501.1 | 96.3 | 57.4 |
| **Үндсэн цалин** | **1,191.3** | **1,144.0** | **1,125.1** | **98.3** | **18.9** |
| Нэмэгдэл | 145.3 | 292.8 | 267.8 | 91.5 | 25.0 |
| **Унаа хоолны хөнгөлөлт** | **29.9** | **39.2** | **34.8** | **88.9** | **4.3** |
| Урамшуулал | 39.2 | 53.7 | 46.0 | 85.8 | 7.6 |
| **Гэрээт ажлын хөлс** | **31.9** | **28.8** | **27.2** | **94.7** | **1.5** |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 0.0 | 0.0 | 0.0 | - | 0.0 |
| **Тэтгэврийн даатгал** | **0.0** | **0.0** | **0.0** | **-** | **0.0** |
| Тэтгэмжийн даатгал | 0.0 | 0.0 | 0.0 | - | 0.0 |
| **ҮОМШӨ-ний даатгал** | **0.0** | **0.0** | **0.0** | **-** | **0.0** |
| Ажилгүйдлийн даатгал | 0.0 | 0.0 | 0.0 | - | 0.0 |
| **Эрүүл мэндийн даатгал** | **0.0** | **0.0** | **0.0** | **-** | **0.0** |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 167.7 | 204.9 | 176.9 | 86.3 | 28.0 |
| **Гэрэл, цахилгаан** | **32.7** | **41.7** | **36.1** | **86.6** | **5.6** |
| Түлш, халаалт | 102.2 | 123.9 | 107.8 | 87.0 | 16.1 |
| **Цэвэр, бохир ус** | **16.8** | **21.1** | **17.7** | **83.9** | **3.4** |
| Байрны түрээс | 16.0 | 18.3 | 15.4 | 83.9 | 2.9 |
| Хангамж, бараа материалын зардал | **89.8** | **106.2** | **95.7** | **90.1** | **10.5** |
| Бичиг хэрэг | 7.4 | 9.4 | 8.3 | 88.8 | 1.1 |
| **Тээвэр, шатахуун** | **31.8** | **37.8** | **35.6** | **94.2** | **2.2** |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 8.5 | 11.2 | 8.8 | 78.5 | 2.4 |
| **Ном, хэвлэл** | **2.9** | **5.5** | **3.3** | **61.1** | **2.1** |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 32.5 | 33.4 | 31.5 | 94.3 | 1.9 |
| **Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс** | **6.7** | **8.9** | **8.1** | **90.7** | **0.8** |
| Нормативт зардал | 187.1 | 235.6 | 209.3 | 0.0 | 26.3 |
| **Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл** | **89.8** | **115.2** | **106.5** | **92.5** | **8.7** |
| Хоол, хүнс | 74.9 | 88.8 | 77.9 | 87.7 | 10.9 |
| **Нормын хувцас, зөөлөн эдлэл** | **22.3** | **31.6** | **24.9** | **78.7** | **6.7** |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 38.4 | 61.6 | 48.5 | 78.8 | 13.1 |
| **Багаж, техник, хэрэгсэл** | **11.2** | **18.2** | **13.7** | **75.0** | **4.6** |
| Тавилга | 1.5 | 4.1 | 1.9 | 45.7 | 2.2 |
| **Хөдөлмөр хамгааллын хэрэглэл** | **0.6** | **1.7** | **1.1** | **65.3** | **0.6** |
| Урсгал засвар | 25.1 | 37.7 | 31.9 | 84.7 | 5.7 |
| Томилолт, зочны зардал | **15.2** | **25.1** | **19.8** | **78.9** | **5.3** |
| Гадаад албан томилолт | 5.6 | 8.9 | 8.3 | 93.1 | 0.6 |
| **Дотоод албан томилолт** | **7.8** | **13.3** | **9.0** | **68.1** | **4.2** |
| Зочин төлөөлөгч хүлээн авах | 1.9 | 2.9 | 2.5 | 84.6 | 0.4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 253.2 | 450.2 | 276.1 | 61.3 | 174.1 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 231.8 | 417.6 | 253.9 | 60.8 | 163.6 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.6 | 1.4 | 0.9 | 65.0 | 0.5 |
| Даатгалын үйлчилгээ | 9.0 | 9.6 | 8.8 | 91.4 | 0.8 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 0.5 | 0.6 | 0.5 | 73.6 | 0.2 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.1 | 0.2 | 0.2 | 72.1 | 0.1 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4.0 | 10.2 | 5.9 | 57.8 | 4.3 |
| Газрын төлбөр | 0.8 | 1.1 | 0.7 | 64.9 | 0.4 |
| Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1.0 | 1.5 | 0.8 | 55.5 | 0.7 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 5.5 | 8.0 | 4.4 | 55.1 | 3.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 205.0 | 282.8 | 199.2 | 70.4 | 83.6 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 180.5 | 249.6 | 174.4 | 69.9 | 75.2 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 24.4 | 33.2 | 24.8 | 74.8 | 8.4 |
| ХҮҮ | 885.7 | 971.1 | 897.4 | 92.4 | 73.6 |
| Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр | 438.9 | 583.1 | 592.8 | 101.7 | -9.7 |
| Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр | 446.9 | 388.0 | 304.7 | 78.5 | 83.4 |
| ТАТААС | 199.5 | 208.6 | 166.8 | 80.0 | 41.8 |
| Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 18.9 | 25.7 | 25.3 | 98.3 | 0.4 |
| Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 180.6 | 182.9 | 141.6 | 77.4 | 41.3 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,920.0 | 2,371.5 | 2,251.3 | 94.9 | 120.2 |
| Засгийн газрын урсгал шилжүүлэг | 13.8 | 87.2 | 59.0 | 67.7 | 28.2 |
| Засгийн газрын дотоод шилжүүлэг | 10.0 | 79.1 | 53.5 | 67.6 | 25.6 |
| Засгийн газрын гадаад шилжүүлэг | 3.8 | 8.1 | 5.5 | 68.2 | 2.6 |
| Бусад урсгал шилжүүлэг | 1,906.2 | 2,284.3 | 2,192.3 | 96.0 | 92.0 |
| Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж | 1,308.1 | 1,486.9 | 1,483.4 | 99.8 | 3.5 |
| Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 372.8 | 517.0 | 493.9 | 95.5 | 23.0 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 3.4 | 5.4 | 4.1 | 76.6 | 1.3 |
| Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 108.0 | 155.9 | 112.8 | 72.3 | 43.2 |
| Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | 0.0 | 0.0 | 0.0 | 32.4 | 0.0 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 55.9 | 70.4 | 55.1 | 78.2 | 15.4 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 53.5 | 39.4 | 37.4 | 94.8 | 2.0 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4.5 | 9.1 | 5.5 | 60.1 | 3.7 |
| ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 932.4 | 1,905.0 | 1,045.7 | 54.9 | 859.3 |
| Барилга байгууламж | 670.9 | 1,154.5 | 591.5 | 51.2 | 563.0 |
| Их засвар | 45.4 | 82.1 | 52.6 | 64.0 | 29.5 |
| Тоног төхөөрөмж | 41.1 | 285.5 | 157.8 | 55.2 | 127.8 |
| Бусад хөрөнгө | 153.6 | 371.0 | 240.9 | 64.9 | 130.1 |
| Стратегийн нөөц хөрөнгө | 21.3 | 11.9 | 3.0 | 24.9 | 8.9 |
| Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт | 0.0 | 0.0 | 0.0 | - | 0.0 |
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 172.9 | 326.2 | 289.7 | 88.8 | 36.5 |
| Эргэж төлөгдөх зээл | 104.8 | 229.9 | 211.2 | 91.9 | 18.7 |
| Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих | 0.0 | 0.0 | 0.0 | - | 0.0 |
| Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | 68.1 | 96.3 | 78.5 | 81.5 | 17.8 |

*Эх сурвалж: Сангийн Яам*

***Нэгдсэн төсвийн нийт зарлагад урсгал зардлын эзлэх хувийн жин 81.4 хувь болж, өнгөрсөн оноос 1.6 пунктээр буурсан байна.***

Нэгдсэн төсвийн нийт зарлагын 81.4 хувь буюу 5,842.2 тэрбум төгрөгийг урсгал зардал эзэлж байна. Урсгал зардлын 43.2 хувийг бараа, ажил үйлчилгээний зардал, 38.5 хувийг урсгал шилжүүлэг, 15.4 хувийг зээлийн үйлчилгээний төлбөр, 2.9 хувийг татаас эзэлж байна.

**График 5.** Урсгал зардлын бүтэц /хувиар/




Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нэгдсэн төсвийн урсгал зардал 442.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд: татаас 32.7 тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч бараа, үйлчилгээний зардал 132.6 тэрбум, зээлийн үйлчилгээний төлбөр 11.7 тэрбум, урсгал шилжүүлэг 331.3 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь нөлөөлжээ.

***Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар 31 төсвийн ерөнхийлөн захирагчдын төсөв зарцуулах эрхийг баталсан бөгөөд 2018 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр тэдгээрийн батлагдсан улсын төсвийн нийт зарлагын төсөв 1,066.2 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагджээ.***

Улсын төсвийн нийт зарлагын 23.8 хувийг Сангийн сайдын багц, 18.2 хувийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багц, 18.0 хувийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багц, 9.4 хувийг Эрүүл мэндийн сайдын багц, 6.4 хувийг Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц, 5.6 хувийг Зам, тээврийн хөгжлийн сайд, 3.2 хувийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын багц, 3.0 хувийг Батлан хамгаалахын сайдын багц, үлдэх 12.4 хувийг бусад төсвийн ерөнхийлөн захирагчдын багцын зардал эзэлж байна.

Улсын төсвийн нийт зардал, төсвийн ерөнхийлөн захирагчаар

*Хүснэгт 6.* /сая төгрөг/

| Төсвийн ерөнхийлөн захирагч | 2018 оны 10 дугаар сарын гүйцэтгэл | | | |
|---|---|---|---|---|
| | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА | 4,686.0 | 3,948.8 | 737.1 | 84.3 |
| **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА** | **30,312.6** | **24,091.8** | **6,220.8** | **79.5** |
| МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД | 188,488.5 | 156,112.3 | 32,376.2 | 82.8 |
| **ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА** | **31,912.2** | **17,556.5** | **14,355.7** | **55.0** |
| ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД | 60,961.4 | 49,798.6 | 11,162.8 | 81.7 |
| **САНГИЙН САЙД** | **1,532,247.8** | **1,339,899.4** | **192,348.4** | **87.4** |
| БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД | 203,352.4 | 169,349.6 | 34,002.7 | 83.3 |
| **ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД** | **653,997.5** | **532,223.6** | **121,773.9** | **81.4** |
| МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА | 1,819.8 | 1,720.5 | 99.3 | 94.5 |
| **УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ** | **3,371.8** | **2,818.1** | **553.7** | **83.6** |
| ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА | 40,648.0 | 38,022.1 | 2,625.9 | 93.5 |
| **УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР** | **24,315.0** | **23,345.9** | **969.0** | **96.0** |
| ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА | 1,814.7 | 1,691.3 | 123.4 | 93.2 |
| **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР** | **9,964.4** | **9,362.5** | **601.9** | **94.0** |
| ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА | 8,203.9 | 6,441.9 | 1,762.0 | 78.5 |
| **САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА** | **3,348.1** | **2,436.2** | **911.8** | **72.8** |
| ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА | 638.9 | 631.6 | 7.3 | 98.9 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА | 565.5 | 379.1 | 186.3 | 67.0 |
| МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД | 115,760.5 | 89,178.4 | 26,582.1 | 77.0 |
| СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА | 999.6 | 889.5 | 110.1 | 89.0 |
| ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА | 949.4 | 787.3 | 162.1 | 82.9 |
| АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА | 13,210.8 | 8,851.1 | 4,359.7 | 67.0 |
| БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД | 76,186.9 | 58,552.4 | 17,634.5 | 76.9 |
| ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД | 409,559.7 | 360,736.1 | 48,823.5 | 88.1 |
| БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД | 128,460.4 | 76,695.5 | 51,764.9 | 59.7 |
| БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД | 1,368,861.6 | 1,025,427.5 | 343,434.1 | 74.9 |
| ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД | 358,721.4 | 318,309.9 | 40,411.5 | 88.7 |
| УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД | 23,569.9 | 15,446.0 | 8,123.9 | 65.5 |
| ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД | 178,523.7 | 182,317.0 | -3,793.3 | 102.1 |
| ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД | 153,468.0 | 108,259.0 | 45,209.0 | 70.5 |
| ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД | 1,074,911.4 | 1,012,396.8 | 62,514.6 | 94.2 |
